

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шимбилэг өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/21/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2024 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533539 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533539 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024. 02. 23 № 90

танай _____-ны № _____-т

ШИМБИЛЭГ ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Л.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шимбилэг өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шимбилэг өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримт бүрдэл дутуу, гэрээт ажлыг дүгнээгүй, бараа материалын зарцуулалтын тайлан хөтлөөгүй, 41,902.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20.2.3, 20.2.6 санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын тушаалаар 6 төсөл хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 5 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 45,059.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

016020160

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 90.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,384,941.77	205,569,174.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	770,352.75	8,624,360.68
311	Кассад байгаа бэлэн мөнгө	195,990.00	106,285.00
3111	Төгрөг	195,990.00	106,285.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	574,362.75	8,518,075.68
3121	Төгрөг	569,512.75	8,513,225.68
31213	Арилжааны банк дахь харилцах	569,512.75	8,513,225.68
3122	Гадаад валют	4,850.00	4,850.00
31223	Арилжааны банк дахь харилцах	4,850.00	4,850.00
33	АВЛАГА	1,624.00	36,218,065.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,624.00	-
333	Татаас, санхүүжилтийн авлага	-	35,518,065.00
335	Бусад авлага	-	700,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	162,612,965.02	160,726,748.82
351	Түүхий эд материал	117,874,276.02	122,366,999.82
3511	Тусгай зориулалттай материал	99,832,330.41	102,633,211.34
3513	Эм боох материал	18,041,945.61	19,733,788.48
353	Бэлэн бүтээгдэхүүн	3,351,350.00	2,228,850.00
354	Хангамжийн материал	41,387,339.00	36,130,899.00
3541	Бичиг хэргийн материал	8,392,200.00	7,605,560.00
3542	Аж ахуйн материал	6,709,494.00	9,253,194.00
3543	Сэлбэг хэрэгсэл	-	1,680,000.00
3544	Түлш, шатах тослох материал	6,580,000.00	500,000.00
3547	Бусад хангамжийн материал	19,705,645.00	17,092,145.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	269,182,152.36	283,962,553.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	269,182,152.36	283,962,553.67
392	Биет хөрөнгө	268,423,819.03	283,464,220.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,510,000.00	74,510,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,365,833.40)	(39,284,166.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	229,344,194.82	279,721,173.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,306,629.77)	(100,997,133.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,610,442.00	95,876,042.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,368,354.62)	(26,361,695.54)
393	Биет бус хөрөнгө	758,333.33	498,333.21
39301	Программ хангамж	2,400,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,641,666.67)	(1,901,666.79)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	432,567,094.13	489,531,728.17
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	87,533,124.42	74,581,824.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	87,533,124.42	74,581,824.42
414	Урьдчилж орсон орлого	87,533,124.42	74,581,824.42
4144	Бусад урьдчилж орсон орлого	87,533,124.42	74,581,824.42
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	345,033,969.71	414,949,903.75
51	Засгийн газрын хувь оролцоо	345,033,969.71	414,949,903.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	78,446,170.00	78,446,170.00
512	Хуримтлагдсан үр дүн	242,275,427.24	312,191,361.28
5121	Өмнөх үеийн үр дүн	242,275,427.24	242,275,427.24
5122	Тайлант үеийн үр дүн	-	69,915,934.04
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,312,372.47	24,312,372.47
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	432,567,094.13	489,531,728.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	954,859,468.25	1,053,612,129.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	656,081,478.25	889,906,179.41
120	Нийтлэг татварын бус орлого	649,408,011.25	786,318,682.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	517,864,606.20	646,504,817.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,964,606.20	646,279,817.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	900,000.00	225,000.00
120009	Бусад орлого	430,000.00	500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,099,469.67	45,059,979.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	123,013,935.38	94,253,885.99
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6,673,467.00	103,587,497.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	6,673,467.00	103,587,497.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	298,777,990.00	163,705,950.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,000,000.00	11,430,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	8,000,000.00	11,430,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,364,800.00	14,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,364,800.00	14,075,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	768,350.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	768,350.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	272,413,190.00	137,431,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	272,413,190.00	137,431,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,050,856,818.04	983,696,195.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,856,818.04	983,696,195.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,220,784.04	869,925,308.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,319,943.00	506,840,007.00
210101	Үндсэн цалин	400,319,943.00	506,840,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,914,927.00	62,777,192.00
210201	Тэтгэврийн даатгал	48,914,927.00	62,777,192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,671,192.00	45,120,109.00
210401	Бичиг хэрэг	10,202,650.00	9,833,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,385,000.00	8,216,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,403,080.00	6,236,359.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	584,890.00	348,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,331,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,095,572.00	16,155,350.00
2105	Нормативт зардал	174,444,140.55	163,052,552.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	173,105,140.55	160,577,232.19
210502	Хоол, хүнс	250,000.00	2,475,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,089,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,180,200.00	418,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,911,200.00	-
210604	Урсгал засвар	1,269,000.00	418,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,914,752.00	13,735,600.00
210702	Дотоод албан томилолт	3,914,752.00	13,735,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,724,049.00	33,687,970.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,312,476.00	31,689,188.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	755,173.00	135,722.49
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,085,000.00	870,000.00

210807	Газрын төлбөр	-	61,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	138,400.00	131,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,051,580.49	44,293,877.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,334.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,551,246.49	44,293,877.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	333,636,034.00	113,770,887.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	333,636,034.00	113,770,887.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	313,369,433.00	10,183,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,266,601.00	103,587,497.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(95,997,349.79)	69,915,934.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,000,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	10,000,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,857,591.32	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,817,591.32	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,040,000.00	-
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,857,591.32)	-
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(102,854,941.11)	69,915,934.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,104,036,763.20	878,555,199.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	524,068,073.20	740,054,249.42
120	Нийтлэг татварын бус орлого	517,394,606.20	636,466,752.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	516,964,606.20	635,966,752.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,964,606.20	635,966,752.42
120009	Бусад орлого	430,000.00	500,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6,673,467.00	103,587,497.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	6,673,467.00	103,587,497.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	579,968,690.00	138,500,950.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,000,000.00	11,430,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	8,000,000.00	11,430,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	299,555,500.00	14,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	299,555,500.00	14,075,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	768,350.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	768,350.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	272,413,190.00	112,226,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	272,413,190.00	112,226,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	967,669,621.50	870,701,191.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	967,669,621.50	870,701,191.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,041,786.00	755,755,364.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,319,943.00	506,840,007.00
210101	Үндсэн цалин	400,319,943.00	506,840,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,914,926.00	62,777,192.00
210201	Тэтгэврийн даатгал	48,773,551.00	62,777,192.00
210202	Тэтгэмжийн даатгал	141,375.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	48,674,560.00	36,518,269.00
210401	Бичиг хэрэг	15,720,450.00	8,362,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,996,700.00	2,659,500.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,403,080.00	6,236,359.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	348,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,139,000.00	4,360,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,319,330.00	14,551,510.00
2105	Нормативт зардал	110,836,007.00	73,898,890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,086,665.00	71,127,570.00
210502	Хоол, хүнс	219,342.00	2,771,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,530,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,269,000.00	29,570,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	17,800,000.00
210602	Тавилга	-	9,645,600.00
210604	Урсгал засвар	1,269,000.00	2,124,920.00
2107	Томилолт, зочны зардал	3,914,752.00	13,735,600.00
210702	Дотоод албан томилолт	3,914,752.00	13,735,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,609,133.00	32,392,888.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,682,560.00	30,398,141.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	755,173.00	131,687.60
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	870,000.00
210807	Газрын төлбөр	-	61,360.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	138,400.00	131,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503,465.00	21,997.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	503,465.00	21,997.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	302,627,835.50	114,945,827.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	302,627,835.50	114,945,827.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	241,220.00	1,197,882.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	1,871,452.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	282,125,213.00	10,684,757.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,261,402.50	103,587,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	136,367,141.70	7,854,007.93
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,040,000.00	-
	Дотоод эх үүсвэрээр	3,040,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,040,000.00)	-
145	Бусад эх үүсвэр	10,000,000.00	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,000,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	143,327,141.70	7,854,007.93
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	770,352.75
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	770,352.75	8,624,360.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,446,170.00	24,312,372.47	345,130,368.35	447,888,910.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,446,170.00	24,312,372.47	345,130,368.35	447,888,910.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(102,854,941.11)	(102,854,941.11)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,446,170.00	24,312,372.47	242,275,427.24	345,033,969.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,446,170.00	24,312,372.47	242,275,427.24	345,033,969.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	69,915,934.04	69,915,934.04
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,446,170.00	24,312,372.47	312,191,361.28	414,949,903.75

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 31,826.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс залруулах боломжгүй тул зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 10,075.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,354.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,721.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг шалгахад төлбөрийн баримтгүй 30,976.8 мянган төгрөгийн 34 ажил гүйлгээ байна.	1	30,976.8	-	-	-	-	-	-	1	30,976.8	1	30,976.8
Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 19,700.0 мянган төгрөгийн 4 хөрөнгө кодгүй, 850.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан боловч бүртгэлээс хасаагүй зөрчил илэрсэн байна.	1	850.0	-	-	-	-	-	-	1	850.0	1	850.0
Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 15,076.0 мянган төгрөгийн 3 хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-
Үндсэн хөрөнгөнд 265 кодтой автомашин хөрөнгө эвдрэлтэй ашиглах боломжгүй нөхцөл байдалтай байсан.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-
Дүн	4	31,826.8	-	-	-	-	-	-	4	31,826.8	4	31,826.8

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ажилчдад 1,354.0 мянган төгрөгийн шинэ жилийн баярын бэлэг олгосон байна.	1	1,354.0	1	1,354.0	-	-	-	-	-	-	-	-
Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй 1,721.2 мянган төгрөгийн урамшууллыг байгууллагын удирдлагад олгосон байна.	1	1,721.2	-	-	-	-	1	1,721.2	-	-	-	-
Урсгал засварын ажил гүйцэтгэх гэрээт ажлыг тайлант хугацаанд дүгнэж гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.	1	7,000.0	-	-	-	-	1	7,000.0	-	-	-	-
Дүн	3	10,075.2	1	1,354.0	-	-	2	8,721.2	-	-	-	-